

**Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төслийн ҮЗЗ-ийн гишүүд
Дорнод, Хэнтий аймгуудад хөтөлбөрийн хэрэгжилттэй
танилцсан ажлын тайлан**

Хугацаа: 2017 оны 10 дугаар сарын 25-наас 28-ны өдрүүд

Хамрагдсан газрууд:

Хэнтий аймаг

- Хэнтий аймгийн ЭМГ-ын удирдлага
- Хэнтий аймгийн, Нэгдсэн Эмнэлгийн БЗДХ-ын кабинет, СДЗШ-ний төв
- Хэнтий аймгийн, Нэгдсэн Эмнэлгийн Сүрьеэгийн кабинет
- МСТН
- МӨАУМХолбоо

Дорнод аймаг

- Дорнод аймгийн Нэгдсэн эмнэлэг, БЗДХ-ын кабинет
- Дорнод аймгийн Нэгдсэн эмнэлэг, Сүрьеэгийн кабинет
- МСТН
- МӨАУМХолбоо-“Ягаан Цээнэ” Өрхийн Эмнэлэг
- "ЛЭОС" ТББ-ын Дорнод салбар (дэд СХА)

Ажилласан бүрэлдэхүүн:

1. Б.Пунцаг ҮЗЗ-ийн Хяналтын Хорооны гишүүн
2. Л.Номин-Эрдэнэ ҮЗЗ-ийн ажлын албаны ажилтан
3. Н.Тамир Олон нийтийн төлөөлөл
4. Г.Золзаяа ХЭҮК-ийн референт

Зорилго:

Дорнод, Хэнтий аймгуудын Глобаль сангийн дэмжлэгтэй ХДХВ/ДОХ, Сүрьеэгийн төслийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай танилцах явдал байлаа.

Энэхүү үйл ажиллагааны зорилтын хүрээнд үр ашиг, үйл ажиллагааны асуудал (хэрэгжилт, техникийн, захиргааны, санхүүгийн), үр дүн болон үр нөлөөг үнэлэлээ. Ажлын баг нь шаардлагатай зөвлөмжүүдийг өгөх болон бусад байгууллагуудын хувьд ашигтай байж болох саналыг авч, орон нутгийн хэрэгцээ, шаардлага, төслийн тогтвортой байдал төслийн ач холбогдлыг үнэлсэн болно.

Аргачлал:

Ажлын баг жишиг баримт бичиг, мэдээлэл түгээлт, материал, гол мэдээллийн эх сурвалжийг хянаж, эмч мэргэжилтэнгүүдтэй ярилцлага хийн асуумж бөглөж, албан болон албан бус хэлэлцүүлгийг зочилсон газрууддаа хийж гүйцэтгэсэн болно.

Хэнтий аймгийн ЭМГ-ын удирдлага

Уулзсан хүмүүс:

1. Хэнтий аймгийн ЭМГ-ын дарга Ц.Гэрэлмаа
2. Хэнтий аймгийн ЭМГ-ын Удирдлага мэдээллийн хэлтсийн дарга Д.Наранмичид
3. Нэгдсэн Эмнэлгийн ДОХ/БЗДХ-ын кабинетийн эмч Н.Эрдэнэцацрал
4. Нэгдсэн Эмнэлгийн Сүрьеэгийн кабинетын зохицуулагч эмч н.Эрдэнэбилэг

Ерөнхий мэдээлэл:

Хэнтий аймаг 83,0 мянган хавтгай дөрвөлжин км газар нутагтай, 68,1 мянган хүн амтай, Засаг захиргааны 17 нэгжтэй, 1894,6 мянган толгой малтай, Аймгийн нэг хүнд 1,2 хавтгай дөрвөлжин км нутаг, бодод шилжүүлснээр 20 толгой мал ногддог. Аймгийн эдийн засгийн гол чухал салбар нь мал аж ахуй. Нийт хүн амын 71,8%-ийг 0-35 насны хүүхэд залуучууд эзлэх ба хөдөөд 36,6% нь амьдардаг.

Монгол улсын нийслэл Улаанбаатар хотоос 330 км зайд алслагдсан, хойд талаараа ОХУ-тай, бусад талаараа Дорнод, Сүхбаатар, Дорноговь, Төв, Сэлэнгэ аймгуудтай хил залгадаг.

Эрүүл мэнд

Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлэг нь 2017 оны 6 сард шинэ байрандаа нүүн орсон. Тус аймаг улсдаа Сүрьеэгийн тархалтаар дээгүүр байранд ордог бөгөөд үйл ажиллагаагаа цаашид улам сайжруулан оношлогоо эмчилгээг цаг алдалгүй хийж байна.

Санал:

- Сум дундын эмнэлгүүдийг Зөөврийн рентген аппаратаар хангавал үйл ажиллагааны үр дүнд үзүүлэх нөлөө өндөртэй.
- Бор-Өндөр сум нь хүн амын суурьшил, хөдөлгөөн ихтэй тул суурин рентген аппарат шаардлагатай байна.
- Ажиллах албан тушаалтнуудыг системтэйгээр сурган хүний нөөцийг бэхжүүлэх хэрэгтэй байна.

Бэлгэвч, тараах материалууд ирдэг боловч урьд жилүүдийнхээс буурсан. Сорьц тээвэрлэлт үр дүнтэй.

БЗДХ-ын кабинет, СДЗШ-ний төв

Уулзсан хүмүүс:

1. Нэгдсэн Эмнэлгийн ДОХ/БЗДХ-ын кабинетийн эмч Н.Эрдэнэцацрал
2. БЗДХ-ын зөвлөгч бага эмч, сувилагч Эрдэнэтуяа

САНХҮҮ: Санхүүжилтийг бэлэн мөнгөөр хүлээн авдаггүй.

ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТ: Бэлгэвч, эм урвалжийн ханган нийлүүлэлт урьд жилүүдийнхээс буурсан. Эм, урвалжийг Монгол Эм-Импексээс захиалж авдаг. Эм,

урвалжийн хангалт үзлэг хийж буй хүмүүст бүрэн хүрэлцдэггүй. Нөөцөнд 24 ш Цепиксин үлдсэн ба хугацаа нь 11 сард дуусах тул хугацаа нь дуусахаас өмнө ашиглах төлөвтэй байна.



ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ: Хүмүүсээ оношлоод халдварт өртсөн хүмүүстээ үйлчилгээг үзүүлэн, эм бэлдмэлийг хүртээдэг. Глобаль сангийн үйл ажиллагааны хэрэгжилт сайн. 1 эмч, 1 сувилагч ажилладаг тул ажлын ачаалал их байна. Түүнчлэн 1 арьс өнгөний эмч энэ чиглэлээр бэлтгэл сургалтанд сууж байгаа ба 1 жилийн дараа сургалтаа дүүргээд ирнэ. PLIZA аппарат ханган нийлүүлсэн боловч кабинетийн хажууд лаборатори байхгүй. 2017 онд тэмбүүгийн халдвар урд оныхоос ихэссэн бөгөөд 37 шинэ тэмбүү илэрсэн ба түүнээс 2 төрөлхийн тэмбүүтэй хүүхэд төрсөн.

2017 оны 9 сарын байдлаар нийт үзлэг-11218 ба урьд онтой харьцуулахад 4,9% өссөн үзүүлэлтэй байна.

2017 онд урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээг эрсдэлт бүлгийн хүн амыг илүү хамруулахаар зохион байгуулж ажиллаж байна. Үүнд: Өсвөр насны оюутан сурагчид Хэрлэн сумын болон хөдөөгийн нийт 1750 оюутан сурагчдад ХДХВ/БЗДХ-аас урьдчилан сэргийлэх сургалт явуулж 4 сумын 891 сурагч, төвийн 982 оюутан сурагчдыг үзлэг, дох, тэмбүүгийн шинжилгээнд хамруулан 5 тэмбүүгийн халдвартай сурагчдыг илрүүлэн эмчиллээ.

Мөн ХДХВ/БЗДХ-ын илрүүлэг үзлэг тус аймагт амжилттай хэрэгжиж байна. Одоогийн байдлаар нийт 3500 гаруй эрсдэлт бүлгийн хүн амд хурдавчилсан шинжилгээ хийгдэж эерэг гарсан шинжилгээнд баталгаажуулах шинжилгээ хийгдэж байна.

- Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хүрээнд нийт 18 сумыг бүсчилэн 4 хувааж одоогийн байдлаар 2 бүсийн сумдаар үзлэг шинжилгээ хийгдэж байна. Нийт 4215 хүнийг үзлэг шинжилгээнд хамруулаад байна.
- Мөн цэрэг татлагаар нийт 600 гаруй цэргийн насны залуучуудад сургалт явуулж үзлэг, шинжилгээнд хамруулсан.
- Улаан тууз СДЗШТөвийн үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулж 2017 оны 10 сарын байдлаар нийт 307 иргэд сайн дурын зөвлөгөө, шинжилгээнд хамрагдсан байна.

2017 оны 2 сараас ЭМГ-ын дэргэд Залуусын Төв байгуулан мэргэжилтэн ажиллуулж Итгэлтэй утас-тай болсон.

ТӨСЛИЙН ҮР ДҮН: Зорилтот бүлэгрүү чиглэсэн үйл ажиллагаа эрчимтэй сайн явагддаг. Төсөл зорилтондоо хүрч чадаж байгаа ба Мөрөн, Хэрлэн сумдад өвчлөл их байгаа нь харагдсан.

ТАЙЛАН: Төслийн тайлагнал сар бүр хийгддэг.

САНАЛ:

1. Хүний Нөөцийг бэлтгэх, ажиллах албан тушаалтнуудыг системтэйгээр сурган хүний нөөцийг бэхжүүлэх хэрэгтэй байна.
2. Аймгийн хэмжээнд БЗДХ-ын өвчлөл 15-44 насныханд илүү тархалттай байгаа тул тэдэнд чиглэсэн үйл ажиллагааг эрчимжүүлэх хэрэгтэй.

ҮЗЭ-ийн ЗӨВЛӨМЖ:

1. БЗДХ-ын өвчлөл ихтэй 15-44 насныханд Бэлгийн Боловсролын талаарх мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх зорилгоор Аймгийн Нэгдсэн Эмнэлгийн ДОХ/ БЗДХ-ын кабинетын дор Facebook хаяг нээн тэдгээр хүмүүст товч ойлгомжтой, залхаахгүй байдлаар мэдээлэл боловсруулан хүргэж энэ талын оролцоог нэмэгдүүлэх нь аль ч талаараа илүү үр дүнтэй болохыг дэлгэрэнгүй тайлбарласан.

Нэгдсэн Эмнэлгийн Сүрьеэгийн кабинет

Уулзсан хүмүүс:

1. Зохицуулагч эмч Эрдэнэбилэг
2. Нэгдсэн Эмнэлгийн Сүрьеэгийн лабораторын лаборант А.Оюунчимэг

САНХҮҮ: Сорьц тээвэрлэлтийн санхүүжилт орж ирдэг.

ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТ: Эм урвалжийг Монгол Эм-Импексээс 4 сараар нь 25%-ийн нөөцтэйгээр захиалж авдаг. Саад бэрхшээл гараагүй байна.



ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ: Өрх, сумдын эрүүл мэндийн төвд Сүрьеэгийн анхан шатны маягтын хөтлөлт, хавьтал, сүрьеэгийн урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааны хэрэгжилтийн байдалтай танилцаж зөвөлгөө өгч сумдын засаг дарга эрүүл мэндийн төв сүрьеэгийн диспансертай хамтран гурвалсан гэрээ байгуулж, хамтран ажиллах зөвлөмж гаргасны дагуу ажиллаж байна. МСТН-тай нягт холбоотой хамтран ажиллаж, нэг кабинетэд суудаг бөгөөд харилцан санал, зөвлөмж солилцон нэг зорилгын төлөө үр бүтээлтэй ажиллаж байна. Түүнчлэн сүрьеэ өвчин илэрсэн тохиолдолд хэвтүүлэн эмчилж, шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй авч байна.

Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын Сүрьеэгийн Лабораторийн тоног төхөөрөмжийг бүрэн ханган нийлүүлсэн боловч өдийг хүртэл тоног төхөөрөмжийг суурилуулж үйл ажиллагааг эхлүүлээгүй байгаад ҮЗЗ-ийн төлөөллүүд шүүмжлэлтэй хандсан.

ТӨСЛИЙН ҮР ДҮН: Одоо сүрьеэгийн хяналтанд 72 өвчлөл бүртгэгдсэн

Шинэ тохиолдол-61 Үүнээс :

- Уушигны идэвхитэй сүрьеэ-29,
- Уушигны бус сүрьеэ-32
- Уушигны түрхэц эерэг сүрьеэ-20,
- Уушигны түрхэц сөрөг-9 - дахилт-8
- Бусад-3 тус тус илэрч сүрьеэгийн эмчилгээнд орж эмчлэгдэж байна.
- Мөн олон эмэнд дасалтай сүрьеэгээр 6 тохиолдол бүртгэгдсэн уушгны сүрьеэ-3 уушгны бус сүрьеэ -3 тус тус эмчлэгдэж байна. 2017 онд бүх сумдын сорьц тээвэрлэлтээр нийт 169 тээвэрлэснээс, уушигны идэвхитэй сүрьеэ-5 илэрч эмчилгээнд орсон.

ТАЙЛАН: Төслийн тайлагнал цаг тухайдаа хийгддэг.

САНАЛ:

- Зөөврийн болон суурин рентген аппараттай болвол илрүүлэг, эмчилгээний чанар хүртээмж сайжрах болно.
- Сорьц тээвэрлэлтийн ажил 2017 оны 6 сараас эрчимтэй явагдаж байгаатай холбогдуулан Лаборантын ажлын ачаалал ихэссэнийг харгалзан үзэж урамшуулал олгох талаар арга замыг эрэлхийлэх хүсэлт гаргасан.

Монголын Сүрьеэтэй Тэмцэх Нийгэмлэг

Уулзсан хүмүүс:

Орон нутгийн зохицуулагч Алтанзул

САНХҮҮ: Санхүүжилтын тайланг тухайн сарын сүүлээр илгээснээр дараа сарын санхүүжилт саадгүй орж ирдэг.

ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТ: Эм урвалжийг Монгол Эм-Импексээс 4 сараар нь 25%-ийн нөөцтэйгээр авдаг. Эмийг өвчтөнгүүдэд цаг тухайд нь өгч байна. Саад бэрхшээл гараагүй.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ: СДЗШ-ний төвүүдийн үйл ажиллагаа сайн. Глобаль сангийн үйл ажиллагааны хэрэгжилт сайн. 10 сайн дурын ажилтан ажиллаж байна. Хоолтой эмчилгээг өвчтөнгүүдийн саналыг харгалзан хоолны цэсийг зохиож өгдөг. Бусад хүмүүст гэрээр нь очиж эмийг түгээдэг.



ТӨСЛИЙН ҮР ДҮН: Зорилтот бүлэг рүү чиглэсэн үйл ажиллагаа эрчимтэй сайн явагддаг. Төсөл зорилтондоо хүрч чадаж байгаа. Эмийн тасалдал гараагүй. Өвчтөний хавьтлын үзлэг оношлогоог 100% хийдэг.

ТАЙЛАН: Төслийн тайлагнал цаг тухайдаа хийгддэг.

Монголын Өрхийн Анагаах Ухааны Мэргэжилтнүүдийн Холбоо

/МӨАУМХолбоо/

Уулзсан хүмүүс:

1. Салбар зөвлөлийн дарга Цэнд
2. Их эмч Ж.Оюун-Эрдэнэ
3. Их эмч О.Сайханбилэг

САНХҮҮ: Глобаль сангаас бэлэн мөнгөөр санхүүжилт хүлээн авдаггүй.

ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТ: Сүрьеэгийн илрүүлэг, оношлуур, эмчилгээний мэдээлэл бүртгэлийг хөтлөх 5 ширхэг журнал болон БЗДХ-ийн 3 ширхэг журнал ирсэн. Эм, урвалж, бэлгэвч, сургалт сурталчилгааны материалаар сүүлийн жилд ханган нийлүүлэлт хийгээгүй. ЭМГ-аас жирэмснээс хамгаалах эм маш бага хэмжээгээр ирсэн.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ: БЗДХ, Сүрьеэгийн эмгэгтэй тохиолдлыг олж илрүүлэн холбогдох шинжилгээнд хамруулан дараагийн шатлалын эмнэлгийн хяналтанд шилжүүлдэг. Өвчтөнгүүд нийгмийн ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлж Өрхийн Эрүүл Мэндийн Төвүүд дээр эм уухгүй байх хүсэлт тавьсаны дагуу өвчтөнгүүд Сүрьеэгийн диспансери дээр эмээ уудаг. Төслийн хүрээнд зохион байгуулагдаж байгаа сургалтуудад эмч, мэргэжилтнүүд жилд тогтмол 1-2 удаа хамрагдаж байна.

ТӨСЛИЙН ҮР ДҮН: Зорилтот бүлэгрүү чиглэсэн үйл ажиллагаа эрчимтэй сайн явагддаг. Төсөл зорилтондоо хүрч чадаж байгаа.

ТАЙЛАН: Сар бүр тоон, улирал бүр нэгдсэн тайланг МӨАУМХолбооруу илгээдэг.

СААД БЭРХШЭЭЛ: Тухайн орон нутгийн 8000 хүн ам дээрээс нь түр оршин суугчдын үзлэг оношлогооны ажлыг хийхэд хүн хүч, санхүүжилт хүрэлцдэггүй тул ажлын ачаалал өндөр. ЭМ-ийн зарласан кампанит ажлуудыг хийснээр төлөвлөгөөт үйл ажиллагаагаа хийж амжилгүй цалгардуулан ард иргэдийн дунд нэр хүнд буурдаг.

Одоогийн байдлаар ӨЭМТ-ийн арай хийн мэргэшүүлсэн шинэ төгсөгчид нь 2 жил анхан шатан дээр ажиллаад цаашид өөр байгууллагаруу шилжихийн тулд цаг нөгцөөсөн байдал ажиглагдаж байна. Энэ нь нийгэмд ӨЭМТ-үүдийн нэр хүндийг унагах гол нөлөөг үзүүлж буй харамсалтай байдлыг үүсгэж буйг тайлбарласан.

САНАЛ:

1. ӨЭМТ-д хүндээ хүрч ажиллах боломж бололцоог бүрдүүлэн урамшуулан дэмжиж хамтран ажиллах хэрэгтэй байгаан дээр зохих цалинг нэмэгдүүлэн тооцож олговол ӨЭМТ-үүд шинэ төгсөгчдийн дамжин өнгөрөх газар бус тэдний зорин ирж ажиллахыг хүсэх газар болж, улмаар анхан шатны эмнэлгийн үйлчилгээний байгууллагын нэр хүнд сайжран цаашлаад чадварлаг мэргэжилтнүүдээр хүний нөөцөө бүрдүүлэх боломж нөхцөл үүснэ.
2. Хүн амд хийж байгаа сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх

3. Урамшууллын системтэй болж , ажлыг идэвхижүүлэх, илүү цагийн мөнгө тооцож олгох
4. 2013 онд батлагдсан ӨЭМТ-ийн нэг иргэнд олгох санхүүжилт нэмэгдээгүйн дээр түр оршин суугчдын санхүүжилт тавигддаггүйг анхаарах цаг нь нэгэнт болсон тул анхаарах шаардлагатайг сануулсан
5. Өрхийн эмнэлэгт бээлий, хөвөн, бент бичгийн цаасны хангалт өгдөггүй.Түүнчлэн дутагдалтай байгаа дараах зүйлүүдээр хангах Үүнд:
 - Сурталчилгааны материал гарын авлага хэвлүүлэх /бичгийн цаас , принтерийн хор , канон /
 - Даралтын аппарат, чагнуур
 - Маск, бээлий, бент

ЗӨВЛӨМЖ:

- Уушгины сүрьеэгийн сэжигтэй тохиолдлыг илрүүлж, үзлэг шинжилгээнд хамруулах
 - ӨЭМТ болон диспансерийн уялдаа холбоог сайжруулах зорилгоор эмч нарыг чадавхжуулах давтан сургалтанд хамруулах
 - Эмч сувилагч нарын үйл ажиллагаанд оролцох идэвх, хандлагыг жигдрүүлэх, анхан шатны маягтын хөтлөлтийг сайжруулах, хэвшүүлэх, мэдээ мэдээллийн бодит байдлыг хангах.

ГИШҮҮДИЙН САНАЛ: Хэнтий аймагт

1. Салбараас сонгогдсон ҮЗЗ-ийн гишүүн цаашид төсөл хэрэгжүүлэгч байгуулагуудтай хамтарч ажиллах, уялдаа холбоог сайжруулах
2. Цаашид төслийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах асуудал дээр анхаарч ажиллах
3. ЭМБ-ын удирдага болон олон нийтийн байгууллагуудын харилцаа холбоог сайжруулах санал зөвлөмж тусгах
4. Байгууллагын хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах асуудал дээр анхаарч ажиллах

ДОРНОД АЙМАГ

Ерөнхий байдал:

Дорнод аймгийн нутаг засаг захиргааны хувьд дээд түвшинд 14 сум, дэд түвшинд 64 багт хуваагддаг. Дорнод аймгийн хүн амын тоо 2000 онд 75,373 байсан бол 2012 оны тооллогоор нийт хүн ам 74.7 болж буурчээ. Үүнээс 55 гаруй хувь нь Чойбалсан хотод амьдарч байна. Хүн амын 70 хувийг 35 хүртэлх насны хүүхэд залуучууд эзэлдэг

Дорнод аймаг тал хээр болон ойт хээр хосолсон 123.5 мянган хавтгай дөрвөлжин км газар нутагтай, хойд талаараа ОХУ-ын Өвөр байгалийн хязгаар, зүүн талаараа БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр, Хянган аймгуудтай хиллэдэг, Баруун урд, баруун талаараа Сүхбаатар, Хэнтий аймгуудтай хиллэдэг.

Тус аймагт ерөнхий боловсролын 11 сургуульд 13285 сурагч, 26 цэцэрлэгт 4488 хүүхэд суралцаж, хүмүүжиж, 900 гаруй багш ажиллаж байна. Дорнод Монголын дээд сургууль, ШСТТС, МСҮТ зэрэг их дээд, тусгай дунд сургуулиудад 1000 гаруй оюутан, сурагч суралцаж байна.

Дорнод аймгийн хувьд БЗДХ, сүрьеэгийн тархалт харьцангуй өндөр бөгөөд хилийн аймаг тул ЭБҮ олон нийт олонтой нь судалгаанаас харагдаж байлаа.

Дэд бүтэц сайн хөгжсөн тул хэвлэмэл материалуудыг хангалттай хэмжээгээр авч хүмүүст хүртээх хэрэгтэй.

БЗДХ-ын кабинет, СДЗШ-ний төв

Уулзсан хүмүүс:

1. БЗДХ-ын Халдвар судлагч эмч П.Оюунмаа
2. БЗДХ-ын кабинетын эмч Б.Дэлгэрмаа
3. Их эмч Г.Хонгорзул
4. Бага эмч Н.Цэцэгтуяа
5. Сувилагч Э.Энх-Учрал
6. Лаборант Д.Оюунбилэг
7. Халдварын эмч Т.Мөнхтуяа

Ерөнхий байдал:

БЗДХ-ын кабинет нь аймгийн нэгдсэн эмнэлгийн харьяанд 3 их эмч, 1 бага эмч, 1 лаборант, 1 сувилагчтай үйл ажиллагаа явуулж байна.

САНХҮҮ: Санхүүжилтийг бэлэн мөнгөөр хүлээн авдаггүй.

ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТ: Эмийн ханган нийлүүлэлт буурсан ба Эм импексээр дамжуулан эмээ авдаг. ГС-аас хангасан эмийг хадгалалтын горим хангасан нөхцөлд тусад нь хадгалдаг. БОЭТ-ын эмийн сангаас сар сараар нь захиалан хэрэглэж, эмийн зарлагын бүртгэлийг хөтлөн тайланд хавсаргадаг. Сумын төвүүдийг эм, бэлгэвчээр хангадаг. Энэ жил ХӨСҮТ-ээс 10 хайрцаг бэлгэвч хүлээн авсан нь урд жилүүдийнхээс харьцангуй багассан байдалтай байна.



ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ:2014 оноос аймгийн хэмжээнд “Эрүүл Цус” аяныг хэрэгжүүлэн ажиллаж байгаа ба 13-аас дээш насны нийт хүн амын дунд идэвхитэй илрүүлэг хийн, шаардлагатай тохиолдлуудад эмчилгээг цаг алдалгүй хийж байна. Багшлах эрхгүй гэсэн шалтгаанаар 2013 оноос хойш эмч мэргэжилтнүүд ЕБС-д эрүүл мэндийн боловсрол олгох сургалт зохион байгуулах боломжгүй болсон. Тэмбүүгийн тохиолдол ихсэж байгаа энэ үед хүүхдүүдэд тэр талын мэдлэг, мэдээллээр хангах хэрэгцээ их байдаг.

- 2017.04,05 саруудын цэрэг татлагын үзлэгээр нийт 899 залуучууд шинжилгээт үзлэгт хамрагдаж серологи эерэг-61 байснаас 8 тэмбүү илрүүлэн эмчилгээнд хамруулсан./заг хүйтэн-4, бэлгийн үү-2, бэлгийн хомхой-2/
- Эрүүл цус-5 аяны хүрээнд өрх сум, аймгийн төвийн 10-н жилийн сургуулийн ахлах ангийнхан, оюутнуудад ЭМГ-аас хийгдсэн шинжилгээт үзлэгээр нийт 3571 хамрагдсанаас серологи эерэг-171 өвчлөл: тэмбүү-24 –г мэдээлэн эмчилгээнд хамруулаад байна.
- ЛЭОС-Дох-гүй ирээдүй ТББ-тай хамтран 9 удаагийн үзлэгээр нийт-130 хүнд үзлэг шинжилгээ хийж тэмбүү-15, заг хүйтэн-19, үтрээний мөөгөнцөр-8, трихомониаз-11, үтрээний үрэвсэл-26-г илрүүлэн эмчилгээнд хамруулаад байна.
- БОЭТөвийн 325 ажилчдыг шинжилгээт үзлэгт хамрагдуулж 2 хавьтлыг эмчилсэн
- Кабинетийн үйл ажиллагаагаар цэргийн анги, зочид буудал, өрхийн эрүүл мэндийн төв, үйлчлүүлэгчдэд нийт 45 хайрцаг бэлгэвч тараасан.
- Аймгийн ХТТ, ГБССН-тэй хамтран Үе тэнгийн сургагч бэлтгэх 3 өдрийн сургалтанд ДОХ/БЗДХ-аас сэргийлэх, бэлгэвчний хэрэглээ сэдвээр хичээл заасан./26 сурагч/

- ЛЭОС ДОХ-гүй ирээдүй ТББ-тай хамтран Эрсдэлт зан үйл бүхий эмэгтэйчүүдэд ДОХ/БЗДХ-аас сэргийлэх , бэлгэвчний хэрэглээ, Эрүүл зан үйл сэдвээр сургалт мэдээлэл 65 хүнд хийсэн ./4 удаа/

“ЛЭОС” ТББ-тай хамтран ажиллаж тэдний зорилтот олон нийт болон хүүхэд залуусруу чиглэсэн сургалт, ухуулгын ажилд тогтмол оролцон, эрүүл мэндийн мэдлэг, мэдээлэл хүргэхэд туслалцаа үзүүлдэг.

Аймгийн хэмжээнд 2013 оноос өмнө ДОХ-ын 8 шинэ тохиолдол бүртгэгдсэн бөгөөд тэдгээрээс 3 нас барсан гэсэн мэдээлэл хүлээн авсан. Ирэх жилүүдээс ДОХ-ын халдвартай хүмүүс албан ёсоор ХӨСҮТ-ээс АНЭ-ийн харьяанд шилжин ирэх болсонтой холбогдуулан зохих бэлтгэлийг ханган ажиллаж байна.

ТӨСЛИЙН ҮР ДҮН: Зорилтот бүлэг рүүгээ чиглэсэн үйл ажиллагаа эрчимтэй сайн явагддаг. Төсөл зорилтондоо хүрч чадаж байгаа.

ТАЙЛАН: Төслийн тайлагнал цаг тухайдаа хийгддэг.

САНАЛ:

- Лабораторит өсгөвөрлөх шинжилгээг хийхэд хүний нөөцийн дутагдалтай
- Нийт хүн амын дунд урьдчилан сэргийлэх үзлэгийг сайжруулах
- Халдварын хяналтыг сайжруулах
- Цаашид бэлгэвчний хангамжийг нэмэгдүүлэх тал дээр анхаарах

ҮЗЭ-ийн ЗӨВЛӨМЖ: Ажлын ачааллыг жигд хуваарилан ажиллахын тулд ӨЭМТ-үүдийг чадавхижуулан тодорхой үүргүүдийг хүлээлгэн өгч, мэргэжил арга зүйгээр дэмжин ажиллах шаардлагатай.

Сүрьеэгийн төсөл

Уулзсан хүмүүс:

1. Зохицуулагч эмч Адьяаням
2. Эм хариуцсан мэргэжилтэн Ч.Алтаннавч
3. Дүн бүртгэгч, бага эмч М.Оюунтуяа
4. Лаборант М.Баярсайхан
5. Лаборант Т.Оюунжаргал



САНХҮҮ: Санхүүжилтийг бэлэн мөнгөөр хүлээн авдаггүй.

ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТ: Эм урвалжийг Монгол Эм-Импексээс 4 сарын нөөцтэйгээр авдаг. Саад бэрхшээл гараагүй. Зөөврийн кварцийн аппараттай. Төслийн хүрээнд 2016 онд GENEXPERT хүлээн авсан.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ: GENEXPERT Төхөөрөмжийг ашиглан өөрийн аймагтаа болон хөрш аймгуудын хүмүүсийн сорьцод шинжилгээ хийдэг. 2017 онд нийт 250 сорьцод шинжилгээ хийсэн. Энэхүү төхөөрөмжтэй болсноор өвчтөнгүүдийн хүлээгдэл чирэгдэл багасч 1 цаг 30 минутын дотор хариугаа гарган авч зохих эмчилгээнүүдийг төлөвлөдөг болсон сайн талтай. СДЗШ-ний төвүүдийн үйл ажиллагаа сайн. Глобаль сангийн үйл ажиллагааны хэрэгжилт сайн. ОДС-ын илрэлт эрчимтэй сайн явагдаж байна. ОЭДС-ийн агааржуулалтын систем суурилагдсан боловч мэдрэг сүрьеэгийн тасгууд нь агааржуулалтын системгүй тул эмч ажилтнууд халдвар авах өндөр эрсдэлд ажиллаж байгаа бөгөөд үзлэгт ороход эмч ажилтнууд бүгдээрээ **уушгины өөрчлөлттэй** гарсан. 2016 оны 10 сараас МСЭМХ-ийн үйл ажиллагааны хүрээнд сорьц тээвэрлэлт тогтворжсон. 2008 онд 8 сум лабораторитой болсон.

4 Их эмч, 1 вакцинатор, 1 бактериологич, 9 сувилагч, 2 лаборант гээд нийт 23 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байгаа нь ажлын ачааллыг бууруулахад эерэг нөлөөтэй байна.

35 ортой сүрьеэгийн болон 5 ортой ОЭДС-ын тасгуудтай.

Цаашид сүрьеэгийн шинэ диспансери нээх үйл ажиллагааны хүрээнд шаардлагатай бэлтгэл ажлуудыг хийж байна.



ТӨСЛИЙН ҮР ДҮН: Зорилтот бүлэг рүүгээ чиглэсэн үйл ажиллагаа эрчимтэй сайн явагддаг. Төсөл зорилтондоо хүрч чадаж байгаа. Эмч мэргэжилнүүд чадавхижуулах сургалтанд байнга хамрагддаг.

ТАЙЛАН: Төслийн тайлагнал цаг тухайдаа хийгддэг.

САНАЛ:

- Мэдрэг сүрьеэгийн тасагт агааржуулалтын систем суурилуулах шаардлагатай.
- Сүрьеэгийн диспансерт засварын ажил хийх хэрэгтэй байна.



ЗӨВЛӨМЖ: Эмч, эмнэлгийн ажилтнуудын халдвар хамгааллыг сайжруулж, цаашид бүх тасгууддаа агааржуулах системтэй болох боломж бололцоог эрэлхийлэх хэрэгтэй.

Монголын Сүрьеэтэй Тэмцэх Нийгэмлэг /МСТН/

Уулзсан хүмүүс:

1. Дорнод аймгийн МСТН-ийн Орон нутгийн зохицуулагч Уранбилэг



САНХҮҮ: Санхүүжилт сар сардаа орж ирдэг.

ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТ: Эм урвалжийг Монгол Эм-Импексээс 4 сарын нөөцтэйгээр авдаг. Саад бэрхшээл гараагүй.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ: Глобаль сангийн үйл ажиллагааны хэрэгжилт сайн. Аймагт 7 идэвхтэн, Баян-уул, Чулуун хороот сумдад 2 идэвхтэн ажиллаж байна. 1 СДИ 2-4 өвчтөнд хүрч ажилладаг ба нийт 21 хүнд хүрч очин эмийг уулгаж байна. Эрүүл Мэндийн сайн дурын 5 ажилтан ажиллаж байна. Сүрьеэгийн тасгийн ажилчидтай нягт холбоотой хамран ажилладаг.

ТӨСЛИЙН ҮР ДҮН: Зорилтот бүлэгүү чиглэсэн үйл ажиллагаа эрчимтэй сайн явагддаг. Төсөл зорилтондоо хүрч чадаж байгаа.

ТАЙЛАН: Төслийн тайлагнал цаг тухайдаа хийгддэг.

САНАЛ: Зарим тохиолдолд ОЭДС-тэй өвчтөнгүүдэд эм зөөх шаардлага гардаг ба энэ тохиолдолд ямар ч урамшуулал өгөхөө больсонтой холбоотойгоор хүрч очих ажилтнууд тэдэнд үйлчлэхээс цааргалах байдал ажиглагддаг. Тиймээс тэдэнд зохих урамшууллыг олгох хэрэгтэй.

Монголын Өрхийн Анагаах Ухааны Мэргэжилтнүүдийн Холбоо

/МӨАУМХолбоо/

“Ягаан Цээнэ” Өрхийн Эмнэлэг

Уулзсан хүмүүс:

1. Салбар зөвлөлийн дарга Саруул
2. Их эмч Ш.Гантөгс
3. Их эмч О.Сайханбилэг
4. Сувилагч Д.Гантулга
5. Асралт-Үйлс ӨЭМТ-ийн дүн бүртгэгч Дамдинлхагва

САНХҮҮ: Глобаль сангаас бэлэн мөнгөөр санхүүжилт хүлээн авдаггүй.

ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТ: Сүрьеэгийн илрүүлэг, оношлуур, эмчилгээний мэдээлэл бүртгэлийг хөтлөх 5 ширхэг журнал болон БЗДХ-ийн 3 ширхэг журнал ирсэн. 2017 оноос эм, урвалж, бэлгэвч, түргэвчилсэн тест, сургалт сурталчилгааны материалаар ханган нийлүүлэлт хийгдээгүй. “ЛЭОС” ТББ-аас 2 хайрцаг бэлгэвч л авсан. Гэвч үйлчлүүлэгчдэд бэлгэвчний хүртээмж хангалтгүй.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ: БЗДХ, Сүрьеэгийн эмгэгтэй тохиолдлыг олж илрүүлэн холбогдох шинжилгээнд хамруулан дараагийн шатлалын эмнэлгийн хяналтанд

шилжүүлдэг. Өвчтөнгүүд нийгмийн ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлж Өрхийн Эрүүл Мэндийн Төвүүд дээр эм уухгүй байх хүсэлт тавьсаны дагуу өвчтөнгүүд Сүрьеэгийн диспансери дээр эмээ уудаг. Төслийн хүрээнд зохион байгуулагдаж байгаа сургалтуудад эмч, мэргэжилтнүүд тогтмол хамрагдаж байна.



ТӨСЛИЙН ҮР ДҮН: Зорилтот бүлэг рүүгээ чиглэсэн үйл ажиллагаа эрчимтэй сайн явагддаг. Төсөл зорилтондоо хүрч чадаж байгаа.

ТАЙЛАН: Сар бүр тоон, улирал бүр нэгдсэн тайланг МӨАУМХолбооруу илгээдэг.

СААД БЭРХШЭЭЛ: Тухайн орон нутгийн хүн ам дээрээс нь түр оршин суугчдын үзлэг оношлогооны ажлыг хийхэд хүн хүч, санхүүжилт хүрэлцдэггүй тул ажлын ачаалал өндөр.

Одоогийн байдлаар ӨЭМТ-ийн арай хийн мэргэшүүлсэн шинэ төгсөгчид нь 2 жил анхан шатан дээр ажиллаад цаашид өөр байгууллагаруу шилжихийн тулд цаг нөгцөөсөн байдал ажиглагдаж байна. Энэ нь нийгэмд ӨЭМТ-үүдийн нэр хүндийг унагах гол нөлөөг үзүүлж буй харамсалтай байдлыг үүсгэж буйг тайлбарласан.

САНАЛ:

1. Нийт ард иргэд, түр оршин суугчидтайгаа ойр ажиллахын тулд анхан шатанд нь оношлогоог нь хийгээд эмчилгээг гардан хийх хүсэлтэй. Энэхүү ажилд түлхэц болох ДОХ, Тэмбүүгийн түргэвчилсэн тестерүүдийг хүлээн авч иргэддээ хүрч ажиллах хэрэгтэй байна.

2. Шинэ төгсөгчдийн дамжин өнгөрөх газар болж байгаа тул тууштай ажиллах чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж цаашдын үйл ажиллагаагаа тогтворжуулан аливаа өвчнийг оношлон, эмчлэх боломж бололцоог бэхжүүлэн ажиллах хүсэлтэй байна.
3. Дээрхи ажлыг хэрэгжүүлэхийн тулд эмч мэргэжилтнүүдийг цогц сургалтанд байнга хамруулж, мэргэжил мэдлэгийг нь тогтмол сайжруулах хүсэлтэй.
4. Нийт оршин суугчдын дунд харуулдан тандалтын судалгааг жилд 1 удаа хийж байх
5. Хүн амд хийж байгаа сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх
6. 2013 онд батлагдсан ӨЭМТ-ийн нэг иргэнд олгох санхүүжилт нэмэгдээгүйн дээр түр оршин суугчдын санхүүжилт тавигддаггүйг анхаарах
7. Өрхийн эмнэлэгт бэлгэвч, бээлий, хөвөн, бент бичгийн цаасны хангамжийг нэмэгдүүлэх
8. Сурталчилгааны материал гарын авлага маш их хэрэгтэй байдаг.

ҮЗЭ-ийн ЗӨВЛӨМЖ:

1. Аливаа өвчлөлд өртөх эрсдэл өндөртэй 15-44 насныханд ЭМ-ийн Боловсролын талаарх мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх зорилгоор Facebook хаяг нээн тэдгээр хүмүүст товч ойлгомжтой, залхаахгүй байдлаар мэдээлэл боловсруулан хүргэж энэ талын оролцоог нэмэгдүүлэх нь аль ч талаараа илүү үр дүнтэй болохыг дэлгэрэнгүй тайлбарласан.
2. Иргэддээ хүрч ажиллахын тулд Хүний эрхийг дээдэлсэн үйлчилгээг нийтэд хүргэн, тэдний нууцыг хадгалан соёлтой үйлчилбэл ард иргэд ирж үйлчлүүлэх сонирхол нь нэмэгдэх болно гэдгийг сануулсан.
3. Өрхийн эмнэлгийн эмч, ажилтнуудад зориулсан сургалтын хөтөлбөрт зөвхөн эмч, эмнэлгийн ажилтнуудын харилцаа, хандлагаас гадна хувь хүний нууц, хүний эрхийн асуудлаар сургалтын асуудлыг нэмж оруулах.

“ЛЭОС” ТББ

Уулзсан хүмүүс:

1. Төслийн менежер Д.Бүжин,
2. Нийгмийн ажилтан Б.Бадамханд
3. Хүрч очих ажилтан Ч.Солонго
4. Хүрч очих ажилтан Э.Өнөрцэцэг
5. Хүрч очих ажилтан Г.Ганцэцэг
6. Хүрч очих ажилтан Э.Туяамаа

САНХҮҮ: Төслийн санхүүжилт тайлангаа сар бүрийн 25-нд өгсөний дараа шилжин орж ирдэг. Үйл ажиллагааны санхүүжилт сайн.



ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТ: Саад бэрхшээл гараагүй. 2015 оны 2-р улирлаас хойш оношлуур, эм, тариа, гарын авлагаар хангагдаж байна.

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ: СДЗШ-ний төвүүдийн үйл ажиллагаа сайн. Глобал сангийн үйл ажиллагааны хэрэгжилт сайн. ЭМГ, Аймаг, сумын Засаг Дарга нар дэмжин ажилладаг. 2009 оноос хойш 4 хүрч очих ажилтантай ажиллаж байна. 2016 оноос хойш тэмбүүгийн 10-аад шинэ тохиолдол бүртгэгдсэн. Нийт тэмбүүгийн 235 тохиолдлоос 128 нь бүрэн эмчлэгдсэн. Цагдаагийн байгууллагад 2014 оноос ухуулан таниулах ажил зохион байгуулж одоо хамтран ажилладаг болсон. Олон нийтэд мазокын шинжилгээ авч байгаа тул үрэвсэлт өвчлөлүүд сайн илэрч байна. Улирал бүр 1 бүлгийн ярилцлага, 1 нуугдмал уулзалт зохион байгуулдаг. Асралт-Үйлс ӨЭМТ-тэй хамтран 115 олон нийтийг хамруулан зөвлөгөө, шинжилгээ хийсэн ба 10% нь өвчлөлтэй гарсныг эмчилсэн. Төслийн хүрээнд зорилтот бүлгийн хүн амыг эрүүлжүүлэх, бэлгэвчний хэрэглээг нэмэгдүүлэх, мэдээллээр хангах үйл ажиллагаануудыг цаг тухайд нь хийгээд явж байна.

Төслийн хүрээнд олгосон утасны зардал болох 70,000₮-ийг эмч нарт урамшуулал болгон өгч илрүүлгийн ажлыг идэвхижүүлсэн.

ТӨСЛИЙН ҮР ДҮН: Тухайн ТББ-ын ажилчдын ур чадвар сайжирсан. Олон нийтээс зан үйлийн өөрчлөлтийн сургалтыг зохион байгуулах хүсэлт гардаг ба урд нь энэ чиглэлээр сургалтанд хамрагдсан хүмүүсийн зарим нь гар урлалаа хийгээд явж буй тохиолдлууд бий.

ТАЙЛАН: Төслийн тайлагнал цаг тухайдаа хийгддэг.

САНАЛ:

1. Хүйсийн тэгш байдлын талаар төсөл бичих хүсэлтэй.
2. Шинэ залуу үеийн хүмүүст харилцаа холбоог сайжруулан ашиглаж ажиллах сонирхолтой
3. Эмзэг, эрсдэлт бүлгийн охидруу чиглэсэн үйл ажиллагааг сайжруулах
4. Хүчирхийллийн талаар гарын авлагатай болох
5. Хүрч очих ажилтнууд сэтгэл зүйн сургалт дамжаанд хамрагдан бусдад дэмжлэг үзүүлэх
6. Олон нийтээс Амьдрах Ухааны сургалтуудад хамрагдах хүсэлт гардаг.

ҮЗЗ-ийн ЗӨВЛӨМЖ:

1. ХЭҮК-ийн төлөөлөл тухайн орон нутагт ажилладаг ажилтнаасаа Хүчирхийллээс ангид байх талаар хууль зүйн дэмжлэг авах бүрэн боломжтойг сануулан, холбогдон ажиллах нөхцлийг нь бүрдүүлж өгсөн.
2. Төслийн хэрэгжилтийг цаашид сайжруулах тал дээр бусад арга зүйн зөвлөгөөг өгч гадаад орноос туршлага судлах боломжийг эрэлхийх хэрэгтэйг санал болголоо.

ГИШҮҮДИЙН САНАЛ: Дорнод аймагт

1. Салбараас сонгогдсон ҮЗЗ-д гишүүн цаашид төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудтай хамтарч ажиллах, уялдаа холбоог сайжруулах
2. Эрүүл мэндийн газрын удирдага болон олон нийтийн байгууллагуудын харилцаа холбоог сайжруулах санал зөвлөмж тусгах
3. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй эмч, ажилчдын ажлын байрны аюулгүй байдлыг хангах, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах зорилгоор дэмжлэг үзүүлэх, урамшуулах
4. Байгууллагын тогтвортой байдлыг хангах асуудал дээр анхаарч ажиллах
5. Байгууллагууд явуулж буй үйл ажиллагааныхаа хүрээнд Facebook хаягтай болж үйлчилгээ хүргэж буй зорилтот олон нийт болон хамруулах шаардлагатай хүмүүсрүү чиглэсэн өвчлөлийн талаар болон бусад холбогдох мэдээллүүдийг товч, ойлгомжтой байдлаар бэлтгэн түгээх хэрэгтэйг онцлон тэмдэглэсэн болно.

ДУГНЭЛТ

2015-2017 оны төслийн төлөвлөгөөний биелэлтийг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж, хянаж байна. Төслийн статистик үзүүлэлт амжилттай хэрэгжиж байгааг харуулж байна.

Эрүүл мэндийн ажилчдын мэдлэг, ур чадвар, тоног төхөөрөмж сайжирсан, зөв мэдээлэл материалыг ашиглаж байна.

Эрүүл мэндийн мэдээлэл түгээгчид, сургалтын төвүүд, үр шимийг хүртэгчид, хэвлэмэл материалыг ашиглан сургалтыг явуулж байна.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчид болон ажилтнууд эрүүл мэндийн хөтөлбөрүүдийг хөгжүүлэх сургалт зохион байгуулах үйл ажиллагааг бүхэлд нь буюу хэсэгчлэн орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлж байна.

Энэхүү төслийн эмзэг бүлгийн хүмүүсрүү чиглэсэн үйл ажиллагаа, ашигласан материал эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгүүд, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаарх иргэдийн хандлага, зан үйлийг өөрчлөхийг хүсч буй байдал нь бусад байгууллагуудын хувьд сайн жишээ юм.

Одоогийн амжилтыг улам сайжруулан цаашид илүү үр дүнтэй, тогтвортой ажиллах суурийг тавьжээ.

Тайлан бичсэн:
ажилтан/

Л.Номин-Эрдэнэ /ҮЗЗ-ийн ажлын албаны

Хянасан:

Б.Пунцаг /ҮЗЗ-ийн Хяналтын хорооны гишүүн/